



Үндэсний статистикийн
хороо

2019.3

Сарын танилцуулга



ИНФЛЯЦ, ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ



АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
ОРШИЛ.....	4
ИНФЛЯЦ.....	5

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 3 дугаар сард	5
Хүснэгт 2. Инфляцын импортын барааны оролцооны түвшин, жил бүрийн 3 дугаар сард.....	6
Хүснэгт 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2019 оны 3 дугаар сард.....	7
Хүснэгт 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, бараа, үйлчилгээний бүлгээр, улс, бүсээр, хувиар, жил бүрийн 3 дугаар сард.....	8
Хүснэгт 5. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувиар, жил бүрийн 3 дугаар сард.....	9

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, 2016-2019 он, жил бүрийн 3 дугаар сард.....	6
Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар =100%), хувь.....	8
Зураг 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, 2019 оны 3 дугаар сард (өмнөх сар=100%).....	10
Зураг 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, 2019 оны 3 дугаар сард	10
Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс, хувь, 2016-2019 он (өмнөх оны 12 дугаар сар=100%).....	11
Зураг 6. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019 оны 3 дугаар сард.....	12
Зураг 7. Бензин, түлшний үнийн индекс, хувь, 2016-2019 он (өмнөх оны 12 дугаар сар=100%).....	12

ОРШИЛ

Инфляцыг хэмжих хэд хэдэн арга байдгийн нэг нь хэрэглээний үнийн индекс юм. Инфляцын түвшинг тодорхойлох, төрөөс санхүү, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж бусад орлогын хэмжээг индексжүүлэх тооцооны гол үзүүлэлт нь хэрэглээний үнийн индекс болдог. Түүнчлэн ХҮИ-ийг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн нэг болох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн аргын тооцоонд болон эцсийн ашиглалтын тооцоог зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхэд ашиглана.

Үндэсний Статистикийн Хороо нь өөрийн чиг үүргийн хүрээнд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээллийг сар бүр цуглуулж, хэрэглээний үнийн индексийг тооцон олон нийтийн хүртээл болгож байна.

Үндэсний Статистикийн Хороо 1991 оноос Олон Улсын Валютын Сангийн аргачлалаар ХҮИ-ийг тооцож эхэлсэн ба түүнээс хойш суурь, сагс, жинг 1995, 2000, 2005, 2010, 2015 онуудад шинэчилсэн. 1991-2006 он хүртэл Улаанбаатар хотын ХҮИ-ээр хэрэглээний үнийн улсын индексийг төлөөлүүлэн тооцдог байсан. 1997 оноос аймгуудын индексийг тусад нь тооцож, зарлаж ирсэн.

Манай улсын нутаг дэвсгэр, газар зүйн байршлаас хамаарч, бараа, үйлчилгээний үнэ, тариф аймгуудад харилцан адилгүй, улсын хэмжээний нийт өрхийн талаас илүү хувь нь аймаг, орон нутагт амьдардаг зэргээс шалтгаалан ХҮИ-ийн тооцоонд аймгийн ХҮИ-ийг оруулах шаардлагатай болсон. 2006 оны 1 дүгээр сараас эхлэн ХҮИ-ийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, олон улсын аргачлалын дагуу улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

2017 оны 4 дүгээр сараас эхлэн ХҮИ-ийг 2015 суурьт шилжүүлэн хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангиллын /ХЗХБҮА/ үндсэн 12 бүлгийн дагуу 373 (Улаанбаатар хотод 344, аймгуудад 238 нэр төрөл) нэр төрлийн бараа, үйлчилгээгээр ХҮИ-ийг тооцож байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Инфляц


Инфляцын түвшин 2016 оны 3 дугаар сард 0.8 хувь, 2017 оны 3 дугаар сард 3.1 хувь, 2018 оны 3 дугаар сард 6.6 хувь гарж байсан бол 2019 оны 3 дугаар сард 6.7 хувь болж өмнөх оныхоос 0.1 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 3 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2016 III	2017 III	2018 III	2019 III
Ерөнхий индекс	100	0.8	3.1	6.6	6.7
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	-0.7	1.0	1.5	2.1
Согтууруулах ундаа, тамхи	4.4	0.0	0.1	0.3	0.2
Хувцас, бөс бараа, гутал	16.6	0.5	0.4	0.6	1.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	0.1	0.4	1.2	0.9
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	0.1	0.1	0.3	0.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	0.1	0.1	0.4	0.4
Тээвэр	14.4	-0.3	0.6	1.3	0.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	0.0	0.0	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	0.1	0.0	0.1	0.3
Боловсролын үйлчилгээ	4.8	1.0	0.2	0.3	0.3
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3	0.0	0.0	0.2	0.2
Бусад бараа, үйлчилгээ	5.4	0.0	0.3	0.4	0.2

Инфляц 2019 оны 3 дугаар сард улсын хэмжээнд 6.7 хувьтай гарлаа. Үүнийг бүлгүүдийн оролцооны түвшингээр авч үзвэл 2.1 нэгж буюу (31.5 хувь) нь хүнсний бараа, ундаа, усны бүлгээс, 1.2 нэгж буюу (17.9 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгээс, 0.9 нэгж буюу (12.9 хувь) нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. 2018 оны 3 дугаар сард хүнсний бараа, ундаа, усны бүлэг инфляцад 23.0 хувиар нөлөөлж байсан бол 2019 оны 3 дугаар сард 31.5 хувь болж, 8.5 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 3 дугаар сард



Хүснэгт 2. Инфляцын импортын барааны оролцооны түвшин, жил бүрийн 3 дугаар сард

	2016 III		2017 III		2018 III		2019 III	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	0.8	100.0	3.1	100.0	6.6	100.0	6.7	100.0
Импортын барааны нөлөө	0.5	59.5	1.3	41.6	3.1	47.4	2.4	36.5

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагс улсын хэмжээнд 373 бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлдэг.

2019 оны 3 дугаар сард инфляц 6.7 хувь гарсны 2.4 нэгж буюу 36.5 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Энэ нь 2018 оны 3 дугаар сартай харьцуулахад нөлөөлсөн хувь нь 10.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2019 оны 3 дугаар сард


Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	<u>2019 III</u> 2018 III	<u>2019 III</u> 2018 XII	<u>2019 III</u> 2019 II
Ерөнхий индекс	100.0	106.7	101.8	100.7
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	108.2	106.5	101.9
Согтууруулах ундаа, тамхи	4.4	104.1	101.3	100.2
Хувцас, бөс бараа, гутал	16.6	107.3	101.7	100.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	108.7	98.8	100.1
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	104.3	100.8	100.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	109.9	101.2	100.5
Тээвэр	14.4	104.9	98.1	100.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.6	99.9	99.9
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	110.7	100.5	100.2
Боловсролын үйлчилгээ	4.8	105.7	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	106.7	102.5	101.1
Бусад бараа, үйлчилгээ	5.4	103.9	101.4	100.4

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.2 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 20.5 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 6.2 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 3.1 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.1 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 8.7 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 9.3 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3 дугаар сард өмнөх оны эцсээс 1.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 6.5 хувь (мах, махан бүтээгдэхүүн 15.1 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлэг 1.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 1.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар =100%), хувь



Хүснэгт 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, жил бүрийн 3 дугаар сард, хувь

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
2016 III	Ерөнхий индекс	100.8	100.7	98.5	101.5	101.3	102.0
	Бараа	99.2	98.9	97.0	100.3	99.8	100.5
	Үйлчилгээ	105.8	105.5	103.9	106.3	107.4	108.1
2017 III	Ерөнхий индекс	103.1	103.0	103.1	103.2	103.7	102.7
	Бараа	103.4	103.3	102.6	103.6	104.4	102.5
	Үйлчилгээ	102.4	102.3	105.1	101.8	101.2	103.7
2018 III	Ерөнхий индекс	106.6	107.7	106.5	104.6	105.7	105.2
	Бараа	107.6	108.8	107.6	105.2	106.5	106.4
	Үйлчилгээ	103.9	104.9	102.8	102.6	102.4	100.7
2019 III	Ерөнхий индекс	106.7	107.5	105.8	106.0	105.0	107.3
	Бараа	106.9	107.7	105.7	106.2	105.5	108.1
	Үйлчилгээ	105.9	106.9	105.9	105.2	102.5	103.8

Хэрэглээний үнийн индексийг бараа болон үйлчилгээний бүлгээр задалж 2018 оноос бүсийн хэмжээнд тооцож эхэлсэн. 2016 оны 3 дугаар сард үйлчилгээний үнийн өсөлт түлхүү явагдаж байсан бол 2019 оны 3 дугаар сард бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт түлхүү явагдаж байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

Зүүн бүсэд барааны үнийн өсөлт 108.1 хувь, Улаанбаатар хотод үйлчилгээний үнийн өсөлт 106.9 хувь гарсан нь бусад бүсээсээ хамгийн өндөр үзүүлэлт байлаа.


Хүснэгт 5. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс,
өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулснаар,
жил бүрийн 3 дугаар сард, хувь

Аймаг, бүс	2016 III	2017 III	2018 III	2019 III
Ерөнхий индекс	100.8	103.1	106.6	106.7
Баруун бүс	98.5	103.1	106.5	105.8
Баян-Өлгий	96.8	105.6	105.0	106.1
Говь-Алтай	104.1	101.5	104.5	105.9
Завхан	102.0	99.0	106.9	104.4
Увс	97.5	102.7	110.2	105.9
Ховд	96.6	103.2	106.5	106.0
Хангайн бүс	101.5	103.2	104.6	106.0
Архангай	102.8	106.7	103.7	107.6
Баянхонгор	102.3	104.1	108.6	104.7
Булган	100.4	102.7	103.3	104.8
Орхон	100.6	101.8	105.2	106.4
Өвөрхангай	103.8	101.1	104.6	108.7
Хөвсгөл	99.7	103.8	103.0	103.1
Төвийн бүс	101.3	103.7	105.7	105.0
Говьсүмбэр	101.6	104.8	105.6	105.7
Дархан-Уул	100.0	102.5	104.9	106.2
Дорноговь	100.9	104.1	103.3	104.6
Дундговь	103.5	108.1	104.8	104.8
Өмнөговь	100.8	102.1	107.3	106.8
Сэлэнгэ	100.3	103.9	107.0	103.2
Төв	103.1	103.4	106.2	104.9
Зүүн бүс	102.0	102.7	105.2	107.3
Дорнод	103.6	103.2	104.3	107.9
Сүхбаатар	101.0	103.1	105.9	106.2
Хэнтий	101.1	102.0	105.6	107.5
Улаанбаатар	100.7	103.0	107.7	107.5


Аймгуудад хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад бүх аймгуудад 3.1-8.7 хувиар өссөний дотор Өвөрхангай аймагт 108.7 хувь болсон нь хамгийн өндөр үзүүлэлт байлаа.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3 дугаар сард өмнөх сараас бүх аймагт 0.2-1.3 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3 дугаар сард Говьсүмбэр аймагт 1.3 хувиар өссөн нь хамгийн их байна.

Зураг 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, 2019 оны 3 дугаар сард (өмнөх сар= 100%)



Зураг 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, 2019 оны 3 дугаар сард (өмнөх сар = 100%)



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2019 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.8 хувь, өмнөх оны эцсээс 1.5 хувь, өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өслөө.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 7.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн дүн 10.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 12.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 хувь, тээврийн бүлгийн үнэ 4.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3 дугаар сард өмнөх оны эцсээс 1.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 5.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 1.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 2.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 2.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотод 2019 оны 3 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 34.6 хувь буюу 119 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 4.9 хувь буюу 17 бараа, үйлчилгээний үнэ буурч, 60.5 хувь буюу 208 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 62 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс, хувь, (өмнөх оны 12 дугаар сар = 100%)



2019 оны 3 дугаар сард мах махан бүтээгдэхүүн оны эцсээс 15.1 хувиар өссөн байна. Үүнд үхрийн махны үнэ 16.2 хувь, хонины ястай махны 20.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.




■ Мах, махан бүтээгдэхүүн ■ Бусад

Зураг 6. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019 оны 3 дугаар сард

2019 оны 3 сард оны эхнээс инфляц 1.8 хувиар өссөний 1.1 нэгж буюу (62.8) хувь нь мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Зураг 7. Бензин, түлшний үнийн индекс, хувь, 2016-2019 он (өмнөх оны 12 сар=100%)



Бензин, түлшний үнэ 2018 онд өндөр хэлбэлзэлтэй байсан бөгөөд нийт 10 удаа үнэ нэмэгдэж 2 удаа үнэ буурч байжээ. 2019 оны 3 дугаар сарын байдлаар бензин, түлшний үнэ оны эцсээс бүх аймагт буурч байгаа бөгөөд улсын хэмжээнд 5.7 хувиар буурсан байна.